



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Сэдэв: Нутгийн удирдлагын тогтолцоог
боловсронгуй болгох

ТАНИЛЦУУЛГА

ТӨРИЙН ОРДОН
2019 он



1.НИЙСЛЭЛИЙГ ОНЦГОЙЛОН ҮЗЭЖ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫНХ НЬ ХУВЬД ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ БАРИМТЛАНА

Үндсэн хуулийн заалт:

13.1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.

Төслийн заалт:

13.1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэж үзэх бөгөөд нийслэл нь хотод, хот нь дүүрэгт хуваагдана. Нийслэлийн хотын дүүргийг хороонд хувааж болно.




2.НУТАГ ДЭВСГЭРИЙГ ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХУВЬД ХУВААХ БОДЛОГЫГ АМЬДРАЛД НИЙЦҮҮЛЖ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО

Үндсэн хуулийн заалт:

57.1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд **аймаг, нийслэлд**, аймаг нь суманд, сум нь багт, **нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд** хуваагдана.

Төслийн заалт:

57.1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд **аймаг, хот нийслэлд**, аймаг нь суманд, сум нь багт, **хот нь дүүрэгт, дүүрэг нь хороонд** хуваагдана.



Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараа шинээр батлах шаардлага тавьж буй Хотын эрх зүйн байдлын хуулиар “Нийслэлийн хот” болон Аймгийн хэмжээний хотын ялгаа, онцлог байдлыг харгалзан тусгайлан зохицуулна. Мөн тус хуулиар Нийслэлийн хотын дүүрэг (одоогийн хороо)-ийн зохион байгуулалтад (нэгтгэх) зохицуулалт хийж, хороонд хувааж болно. Түүнчлэн аймаг нь хотоосоо, сум нь дүүргээсээ ялгагдах онцлогтойг харгалзан Аймгийн эрх зүйн байдлын тухай хууль, Сумын эрх зүйн байдлын тухай хууль, Дүүргийн эрх зүйн байдлын тухай хуулийг тус тусад нь батлан гаргах шаардлага тавигдана. Мөн засаг захиргааны нэгж доторх тосгоны эрх зүйн үндсийг тогтоосон хуулийг гаргана.



3.3 АСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ ТУС БҮРИЙН ОНЦЛОГИЙГ ХАРГАЛЗАН, ТУСГАЙЛАН ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БИЙ БОЛНО

Үндсэн хуулийн заалт:

57.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

13.2. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Төслийн заалт:

57.2. Аймаг, хот, сум, дүүргийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

13.2. Нийслэл бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн бөгөөд эрх зүйн үндсийг нь зөвхөн хуулиар тогтооно.



4.3 АСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙГ “ӨӨРЧЛӨХ” АСУУДЛЫГ НЭГДМЭЛ УЛСЫН ОНЦЛОГТ ТОХИРСОН БАЙДЛААР ЗОХИЦУУЛНА

Үндсэн хуулийн заалт:

57.3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Төслийн заалт:

57.3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг үндэслэн гаргасан Засгийн газрын саналыг харгалзан Улсын Их Хурал шийдвэрлэнэ.



5.АЙМАГ, ХОТ, НИЙСЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААГ СУНГАНА

Үндсэн хуулийн заалт:

59.3. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг **дөрвөн** жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

Төслийн заалт:

59.3. Аймаг, **хот** нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг **таван** жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.



6.ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЧИГ ҮҮРЭГ, ЭРХИЙГ “ТӨРИЙН УДИРДЛАГЫГ НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХОСЛУУЛАХ” ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦҮҮЛНЭ

Үндсэн хуулийн заалт:

60.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.

Төслийн заалт:

60.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ. Хотын Захирагч харьяалах нутаг дэвсгэртээ Засаг даргын үүргийг хавсран гүйцэтгэнэ.



7.АЙМАГ, ХОТ, НИЙСЛЭЛ, БАГ, ХОРООНЫ ЗАСАГ ДАРГЫГ 5 ЖИЛИЙН ХУГАЦААГААР ТОМИЛНО

Үндсэн хуулийн заалт:

60.2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.

Төслийн заалт:

60.2. Аймаг, хот, нийслэлийн Засаг дарга /Захирагч/-ыг аймаг, хот, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлаас нэр дэвшүүлж Ерөнхий сайд; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус таван жилийн хугацаагаар томилно.

Ерөнхий сайд аймаг, хот, нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэг удаа нэр дэвшүүлж Ерөнхий сайд томилно.



8.СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫГ ИРГЭД 5 ЖИЛИЙН ХУГАЦААГААР СОНГОНО

Үндсэн хуулийн заалт:

60.3.Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.

Төслийн заалт:

60.3.Сум, дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд **таван** жилийн хугацаагаар сонгож, аймаг, хотын Засаг дарга /Захирагч/ арван тав хоногийн дотор батламжилна. **Сум, дүүргийн Засаг даргын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.**



9.СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫГ ОГЦРУУЛСАН БОЛ СОНГУУЛЬ ЯВУУЛАХГҮЙГЭЭР ТОМИЛНО



Төслийн заалт:

60.4.Аймаг, хот, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг хуульд заасан үндэслэл, журмаар чөлөөлж, огцруулна. Сум, дүүргийн **Засаг даргыг огцруулсан бол** бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг **аймаг, хотын Засаг дарга /Захирагч/ томилно.**



10. ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№1)

Үндсэн хуулийн заалт:

58.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

58.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

Төслийн заалт:

58.1. Аймаг, ХОТ, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

58.2. Аймаг, ХОТ, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.



10. ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№2)

Үндсэн хуулийн заалт:

59.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

Төслийн заалт:

59.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, ХОТ, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.



10.ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№3)

Үндсэн хуулийн заалт:

61.1.Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.

Төслийн заалт:

61.1.Засаг дарга /Захирагч/ тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.



10. ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№4)

Үндсэн хуулийн заалт:

61.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.

Төслийн заалт:

61.4. Аймаг, ХОТ, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга /Захирагч/ -ын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.



10.ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№5)

Үндсэн хуулийн заалт:

61.2.Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.

61.3.Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.

Төслийн заалт:

61.2.Засаг дарга /Захирагч/ тухайн аймаг, хот, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.

61.3.Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга /Захирагч/ уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.



10.ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№6)

Үндсэн хуулийн заалт:

62.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

Төслийн заалт:

62.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, ХОТ, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.



10.ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№7)

Үндсэн хуулийн заалт:

62.3.Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр **аймаг, нийслэлийн** Хурал, Засаг даргад шилжүүлж болно.

Төслийн заалт:

62.3.Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр **аймаг, ХОТ, нийслэлийн** Хурал, Засаг дарга /Захирагч/- д шилжүүлж болно.



10.ЗАРЧМЫН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮДТЭЙ ХОЛБОГДУУЛАН БУСАД ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА (№8)

Үндсэн хуулийн заалт:

63.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.

63.2.Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Төслийн заалт:

63.1.Аймаг, ХОТ, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга /Захирагч/ захирамж гаргана

63.2.Хурлын тогтоол, Засаг дарга /Захирагч/ -ын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА